

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХДУГААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

7 дахь жилдээ

№ 37 (2301)

1974 оны 5 дугаар сарын 13

ДАВАА

ЭДИЙН ЗАСАГ-НАМЫН АЖЛЫН ГОЛ ФРОНТ

Эдийн засаг намын ажлын гол фронт байх зарчим нь намын байгууллагын өдөр тутмын ажилд тусгалаа олж, зохиосон ажлын үр дүнгийн хэмжүүр болж байна.

Нөхөр Ю. Цэдэнбал НАШБ-ын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөн дээр хэлсэн үгэндээ намын ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгож, юуны өмнө эдийн засгийн хөгжилд намын нөлөөг хүчтэй болгохын чухалыг онцлон заасан билээ.

Намын байгууллага үзэл суртал зохион байгуулалтын хувьд үлэмж бэхжиж, социализм байгуулах үйлсэд шинэ шинэ хувь нэмэр оруулж, аж ахуй соёлын байгуулалтын зорилтыг шийдвэрлэхэд улам илүү идэвхтэй нөлөөлж, дэвшил хөгжлийг түргэтгэхэд гол шалтгаалах хүч бололцоо нь болж байгааг саяхан болж өнгөрсөн намын анхан шатны байгууллагын тайлан сонгуулийн хурлын дүн харууллаа.

Намын анхан шатны байгууллагын тайлан сонгуулийн хуралд 560 гаруй коммунистууд үг хэлж санал гаргасан нь хүсэл эрмэлзэл, зохион бүтээх хүчирхэг эрч хүчний нэгдэл болох гаргасан шийдвэрт тусгалаа оллоо.

Аймгийн намын бага хурал угтсан өрнүүн хөдөлмөрийн өдрүүдэд үйлдвэрийн газрууд эхний 4 сарын бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг 113,9 хувиар биелүүллээ. Манай алдарт малчид гарсан төлөө 98,8 хувиар бойжуулж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад малын зүй бусын хорогдлыг 6000 толгойгоор буурууллаа.

Тариалалчид хаврын тариалалтын бэлтгэлийг сайн хийж тариалалтын ажилдаа шамдаж байна.

Коммунистууд намын эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх үйлсийн тэргүүн эгнээнд яаж намын малчин гишүүдийн 90 гаруй хувь нь Намын Төв Хорооны IX бүгд хурлын шийдвэрт заасан хэмжээнээс төлөө давуулж бойжуулах боломжтой болов.

Аймгийн намын XVI бага хурал энэ 6 дугаар сарын сүүлчээр хуралдаж, намын байгууллагын ажилд дүн шинжилгээ хийж, намын ажлыг боловсронгуй болгон үр нөлөөг дээшлүүлэх арга замыг тодорхойлон заах болно.

Ийм учраас намын анхан шатны байгууллага коммунист бүр, намынхаа бага хуралд бэлтгэх явцад 1974 оны эхний хагас жилийн аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд нөөц бололцоог бүрэн дайчлах үйлдвэрлэлийн бүх салбарт эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд анхаарлаа чиглүүлж ажиллах нь чухал.

Аймгийн намын анхан шатны байгууллагууд социалист уралдаанд түрүүлэгчдийн чуулга уулзалтаас гаргасан уриаллыг хэрэгжүүлж социалист уралдааны хэлбэр агуулгыг баяжуулж дүгнэх, сурталчлах ажлыг улам эрчимжүүлэх ёстой.

Мөн үйлдвэр аж ахуйн газруудын үйлдвэрлэлийн төлөвлөгөөний явцыг нам, олон нийтийн байгууллагуудаас удирдах удирдлага, тавих хяналт шалгалтыг сайжруулж сар улирлын төлөвлөгөөг давуулан биелүүлэх хөдөлгөөнийг эрчимтэй өрнүүлж ажиллавал зохино. Тэрчилэн гарсан төлийн арчилгаа маллагааг сайжруулж хорогдолгүй бойжуулах, малын зүй бусын хорогдлыг гаргахгүй байх, хаврын тариалалтыг агротехникийн шаардлагын дагуу богино хугацаанд явуулахад зохион байгуулалтын тодорхой удирдлагаар байнга хангаж ажиллах хэрэгтэй.

Мөн намын үзэл суртал ухуулга олон түмний ажлыг аж ахуйн ажилтай нягт холбож түүнд жинхэнэ үйлдвэрлэн бүтээгчдийг өргөн хамарч оролцуулж байвал зохино.

Ялангуяа НАШБ-ын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөнөөс дэвшүүлсэн зорилт МАХН-ын Төв Хорооны VII бүгд хурлын шийдвэрийг бүтээлчээр хэрэгжүүлэхэд НАШБ-ууд ажлынхаа арга барил, үр нөлөөг улам өндөржүүлж ажиллах шаардлагатай байна.

АЙМГИЙН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНД

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийн өргөтгөсөн хурал саяхан Алтанбулаг суманд болж, малын төл бойжилтын байдлыг шалгасан дүнг хэлэлцлээ.

Тус суманд бод мал ил төлөж эхэлмэгц 63 тугал хорогджээ.

Хурлын айнаарал тугал хорогдуулсан шалтгааныг тал бүрээс судлан илрүүлж арга хэмжээ авч чиглэгдэв.

Сум - нэгдлийн дарга П. Лувсанбалдан гол анхаарлаа бог малын төл бойжуулахад чиглүүлээд цагийн аятайд тайвширч, хаваржилтанд хайнга хандсанаас нийм тусгүй байдалд хүрлээ.

Бригадын хариуцлагатай, мал аж ахуйн мэргэжилтэн, ажилчин, албан хаагчдын ажлын хариуцлага суларснаас үйлдвэрлэлд хохирол учрах явдал гарсаар байна.

Бэлтгэж авсан өвсмаань сүрхий харлаж чанар нь мууджээ.

Ингээд л арчилгаа маллагааны муугаас тугал

хорогдов гэж ярих.

Хуралд тавигдсан санал дүгнэлтээс үзэхэд тус сум-нэгдэлд анхан шатны тоо бүртгэл бараг хөтлөгдөөгүй, хяналт шалгалт сулаас хүмүүст хорогдсон тугалыг нууж хаах боломж олгосон ажээ. Уралдааныг урсгалд нь тавьсан газар гэвэл энэ сумыг нэрлэж болох байна. Одоо хүртэл суурийн үйлдвэрлэлийн даалгавар өгөгдөөгүй, малчид уралдаанд ямар үүрэг авснаа ойлгоогүй, шууд дээрээс зохион байгуулж уралдааны үүргийн хуудас дээр хэдэн зохиомол тоотавиж өгчээ. Тэр тоогоо дарга нь ч тайлбарлаж чаддаггүй, малчин нь ч ухаарч мэдэлгүй өдий хүрсэн нь гайхалтай.

Тухайлвал: Нэг саальчинд ноднин 9 үнээ сувайрсан байхад сувайралтыг 10 хувиар багасга гэж үүрэг авахуулсан нь 9 үнээний 10 хувьд нь нэг үнээ оногдож чадахгүй байна.

Мөн 100 хээлтэгчээс 70 тугал, 75 унага бойжуу-

лахаар үүрэг авахуулсан нь нам, засгаас дэвшүүлсэн зорилттой нийцэхгүй байна. Тэрчилэн Баасанжавын суурийн саальчид; Олон улсын эмэгтэйчүүдийн баяраар бидэнд 10—50 төгрөгийн шагнаал өгсөн. Бодвол ноднингийн уралдааныг шагнал байх.

Бүх саальчдын дундаас хэдэд ороод яагаад шагнаал авч байгаагаа мэдэхгүй байна гэж ярьж байгаа нь энд ухуулга сурталчилгааны ажил ихээхэн суларсныг харуулав.

Сумын хэмжээгээр хорогдсон тугалын 85 хувь Алтанбулаг бригадад байгаа нь энэ бригадын малын бага эмч Шагдарсүрэн тугалын хорогдлыг зогсоох талаар олнгой арга хэмжээ аваагүй, түүгээр ч үл барам 5000 гаруй төгрөгийн үнэтэй эмийг ямарч тайлан тооцоогүй тараан, үрэн тараан хийж, 54 тугал хүэд байхад нэгд нь ч акт бичээгүй байжээ.

Ийм хариуцлагагүй хандсан уршаар тэр олон (Төгсгөл нь II нүүрт)

Бүх нийтийн коммунист субботник

ӨРНҮҮН БҮТЭЭЛ

Аймгийн төвийн нийт үйлдвэрийн ажилчид тавдугаар сарын 5-ны «Ням» гарыгт хэмнэж хуримтлуулсан түүхий эд материалаараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж олсон орлогоо хуримтлалын фондод оруулах хөдөлгөөн өрнүүлэн ажиллав.

Энэ өдөр аймгийн төвийн үйлдвэр аж ахуйн газруудын ажилчид өөрсдийн хөдөлмөр бүтээлийн үр шимийг нийгэмдээ зориулахаар эзэмшиж байгаа машин техникийнхээ эрч, хүч, ажил хөдөлмөрийнхөө амжилт бүтээлийг улам өндөржүүлэн ажиллаж байгаагаа.

НААУГ-ын оёдолын I, 2 дугаар ээлжийнхэн хэмнэж хуримтлуулсан даавуу, хөвөнгөөр хүүхдийн хувцас, бээлий, хивсэн тасгийнхан өөдсөн утсаар орны матрас 76-г хийн 166 диметр хивс нэхэв.

Хивсчин С. Зэсэндэг өдөрт 10 диметр хивс нэхэхээс 21 диметр хивс нэхэж, Д. Оюунчимэг 7 орны матрас хийж оёдолчин Хишигхүү өдрийн нормоо 181,3 хувиар биелүүлэв. «Анхдугаар таван

жил»-сонины СХ-ийн үйлдвэрийн ажилчид 237 төгрөгийн ажил хийхээс 280 төгрөгийн ажил хийж хэвлэгч Ч. Алтангэрэл нэг өдөрт 10,1 мянган даралт хуудас хэвлэхээс 14,0 мянган даралт хуудас хэвлэж нормоо 138,7 хувиар, дэвтэрлэгч Л. Гүрэлмаа 750 захиалын дугтуй хийхээс 850 дугтуй хийж нормоо 113,4 хувиар, үсэг өрөгч Ж. Дэжид өрөлтийн нормоо 102,5 хувиар биелүүлсэн байна.

Аймгийн Барилга угсралтын конторынхон 2325 төгрөгийн ажил хийсний дотор Д. Намсрай, Я. Жалбаа даргатай бригадууд барилгын өрлөг шавардлагын ажил хийж 369—472 төгрөгийн хуримтлал оруулж барилгачин С. Сосорбарам, Н. Даш, У. Ойдов, жолооч Л. Батдэлгэр нар өдрийн нормоо 1—250 хувиар давуулжээ.

Ийнхүү аймгийн төвийн үйлдвэр аж ахуйн газрын ажилчид өрнүүн бүтээлтэй 5 ны өдрийг өнгөрүүлжээ.

Д. БАДАРЧ

Тариалалтын

явц

Аймгийн хэмжээгээр 5 дугаар сарын 8-ны байдлаар 54,4 мянган га-д үрлэлт хийж төлөвлөгөөний 45,8 хувийг биелүүлээд байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 21,4 хувиар илүү байна. Үр тариа тариалалт аймгийн хэмжээгээр 51,4, САА-нууд 56,6, ХАА-н нэгдлүүд 56,9, ТАА-нууд 29,4 хувиар тус тус биелүүлээд байна.

Тариалалтыг сумдаар үзүүдбэл (хувиар)

Алтанбулаг	100,0
Батсүмбэр	69,2
Баян	53,3
Баян-Өнжүүл	0
Баяндэлгэр	92,8
Баянгаргалан	100,0
Баянзүрх	—
Баянцагаан	0
Баянцогт	35,0
Борнуур	61,0
Бүрэн	0
Дэлгэрхаан	—
Жаргалант	45,6
Заамар	72,6
Лүн	76,4
Мөнгөнморьт	50,4
Өндөрширээт	20,7
Сэргэлэн	—
Угтаал	79,0
Эрдэнэ	6,5
Эрдэнэсант	39,2
Статистикийн товчоо	—

АЙМГИЙН АДХ—ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНД

Төгсгөл. (Түрүүч нь 1-үүрт)

тугалыг ямар өвчнөөр хэрхэн үхснийг одоо акт бичих болоход мэдэхгүй байна. Алтанбулаг бригадынхан нар гийж, салхи сэнгэнэсэн пүнзэнд тугааа бойжуулж байгаагаас хатгалгаа авч уураг сүү нь шингэхгүй зангиран, хэвтэр тэжээл ус дутаж тугал хоргодож байна.

Төл хоргодож байгаа суурьт тодорхой хугацаагаар сууж, гардан эмчилгээ хийдэггүй, хам хүм дайрч өнгөрснөөр малын эмч нар сэтгэл амардаг нь хоргодлыг таслан зогсоход муугаар нөлөөлж байна. Тэжээл эмчилгээний цэгт он гарсаар цугларсан малын 22,7 хувь нь үхсэн байхад түүнийг хариуцсан бага эмч Б.Байраа эмчилгээг сайжруулахгүй байна.

Тугал, тэжээл эмчилгээний цэгийн мал олноор хоргодож байхад нэгдлийн хянан байцаах комиссын дарга М. Лувсандамдин, АХШ группийн дарга Ш. Динам нар нүд балай, чих дүлий сууж хяналт шалгалтын ажлыг цалгардуулжээ.

Алтанбулаг сумын хариуцлаганы дотроос ажлын үеэр архи хэтрүүлэн ууж ажил хийдүүлдэг замбараагүй байдал газар авчээ. Ийм хүмүүсийн тоонд нэгдлийн орлогч дарга

Л. Нонж, малын бага эмч Б. Байраа, Шагдарсүрэн, малын их эмч Ш. Түмээ, нэгдлийн ня-бо Л. Луунай, тоо бүртгэгч М. Цэдэн, кино механикч Жамъян нар орж байна.

Ер нь энэ сумын нам, захиргаа, олон нийтийн байгууллага ажилчдын зөвлөлгөөн хийх, тэдний эрэлт хүсэлтийг сонсох, хүнтэй ажиллах явдал хангалтгүй, хамт олныг хүмүүжүүлэх ролыг дээшлүүлэггүйгээс нийгэмд хохирол учруулдгийг тус сумын ажил байдал харууллаа.

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийн хурал Алтанбулаг сумын хариуцлагатан мэргэжилтнүүдэд төлийн хоргодлыг зогсоох, ажилтны хувийн хариуцлага, санаачлагыг жигд сайжруулах, архи ууж согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох, сум-нэгдлийн ажлыг сайжруулах тодорхой үүрэг даалгавар өглөө. Тус хурлаас төлийн хоргодлыг зогсоох тодорхой арга хэмжээ аваагүй, хүмүүст тавих зарчим шаардлагыг сулруулсан сум-нэгдлийн дарга П. Лувсандамдин дутагдлаа засахыг анхааруулж ажил хариуцлагагүй хандсан малын их эмч Ш. Түмээ, бригадын дарга Лувсандорж нарыг долодож арга хэмжээ авлаа.

ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛНО

Саяхан аймгийн Намын хорооны товчооны хурал болж илгээлтийн эздийн ажлыг дүгнэх, тэднийг тэргүүний сайчуудын жишээгээр тогтвор суурьшилтай ажиллуулах, арга туршлагыг нь харилцан солилцуулах зорилгоор аймгийн илгээлтийн эздийн анхдугаар чуулга уулзалтыг 1974 оны 5 дугаар сарын 23-нд Зуунмод хотын төвд хийлгэхээр шийдвэрлэв.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

Эх орны тариалангийн талбайд

ЖАРГАЛАНТ-ТАРИАЛАНЧДЫН НУТГААР

Үр суулгах ажил ид өрнөж байгаа Жаргалантын САА-н механикжуулагч тариаланчдын хэнтэй нь ч уулзсан цаг агаарын байдал эрт дулаарч хөрсний гэсэлт түргэсэн чийг сайтан байгаагаас тариалын ургах нөхцөл бүрдэж байгаад урамтай байна гэцгээв.

Ажил үйлсээрээ аж ахуйдаа түрүүлж яваа Талбулагийн тасгийн бригад, салааныхан бүх ард түмний социалист уралдааны тэргүүний сайчуудын чуулга уулзалтын уриалгыг хэрэгжүүлэн 6 өдрийн ажлыг 4-5 өдөрт багтаан хөдөлмөр материалыг хэмнэн ажиллаж байгаагаа ярьж байлаа.

МАХН-ын гишүүн Баточир даргатай Агитын бригад 1638 га-д хаврын хагалгаа хийхээр 9 аргат гаргаж өдөр бүрийн хээ төлөвлөгөөг тогтмол давуулан 3415 га газар үр суулгах ажлаа 5 дугаар сарын 10-нд дуусгахад техник, хүн хүчний тооцоо гаргаж өдөрт 70 га хагалж, 400 га талбайг үрлэж байна. Мөн тасгийн 4 бригад, 8 салаа Майн байр угтсан өндөр бүтээлийн ажил зохиож энэ хугацаанд 3000 гаруй га газар хагалж, 1200 га-д үр суулгасан амжилтыг Г. Лувсандорж даргатай Тээлийн бригад, Дамдамба даргатай Хар-толгойн бригад хошуучилсны дотор тус тасгийн тэргүүний тракторчин БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Ч. Дугарсүрэн, улсын аварга комбайнч О. Ойдовжугнай, Дамдинсүрэн нарын олон сайчууд 6 өдрийн ажлыг 4 өдөрт хийжээ.

Талбулагийн тасагтай

уралдаантай ажиллаж байгаа намын гишүүн Чунатдорж даргатай төвийн тасгаар орвол үр тарианы 3000 гаруй га газар хаврын хагалгаа хийж төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнний 500 гаруй га газрын хөрснийг бордож боловсруулан хүнсний ногооны 50-наад га газар 1550 тонн бордоогоор бордож, үр тарианы 2000 га-д эрдэс бордоогоор бордон 1260 шоо метр талбайд байцааны үр үрслүүлжээ.

Хүнсний ногооны бэлтгэлийг ханган үрслэг ургуулах ажилд улсын аварга ногоочин, МХЗЭ-ийн гишүүн Н. Сувдаа, илгээлтийн эзэн, ногоочин Хаш-эрдэнэ, ногоочин Гүндсамбуу, Баасанхүү, тракторчин Балжинням нар 6 өдрийн ажлыг 5 өдөрт хийж, улсын 4 удаагийн аварга комбайнч, намын гишүүн Уртнасан, Унгар бороожуулагч машины урсгал агаарны аргатгыг СК-4 комбайны моторт тохируулан угсарч хэрэглэснээр усалгааны хүчин чадлыг үлэмж ахиулж хөдөлмөрийн бүтээлийг 3 дахин нэмэгдүүлжээ.

Хөрсний эвдрэлтэй тэмцэх шинэ техникүүдээр хагалгаа, үрлэгээг хийж яваа хүмүүсийн ажлын чанарыг шалгаж явахад нь САА-н дарга, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Д. Арьяатай уулзахад: —Хөрсний эвдрэлтэй тэмцэх арга технологийг Загдал тасгийн 3 бригадын үйлдвэрлэлд нэвтрүүлж хөрснийг хавж боловсруулах, зурваслан тариалах аргыг хэрэглэхдээ салхины чиглэл, хөрсний чийгийн байдал, хог ургамлын тархалт, усны

эвдрэл зэргийг талбай бүрээр нарийн шинжлэн судалж хэдий хугацаанд агро-техникийн ямар арга хэрэглэн ямар техникээр тариалахыг бригад, салаа, талбай бүрээр товлон зааж өгсөн. Хөрс нь салхинд ихээхэн үлээгддэг 10, 12 дугаар бригадуудыг салхины чиглэлийн эсрэг хөндлөн зурваслаж хагалан тариалж байна.

Хаврын салхины хүч нөөлөг голлон ирдэг талбайн хөрсний бүтцийг харгалзан 50-70 метр өргөн зурваслалаа.

Түүнчилэн хөрснийг салхи, усны эвдрэлтэй тэмцэхэд талбайд өвөл цац тогтоох, гүн хагалж сийрүүлэх аргыг хослон хэрэглэж байгаа нь үр дүнтэй болж байгаа гэв.

Улсын ургац хураалтын 5 удаагийн аварга, намын гишүүн Н. Намсрай даргатай бригад энэ жил 1781 га газар «КПП-22» маркийн сийрүүлэгчээр 19-20 см гүн хаван боловсруулж «СЗП-36» маркийн үрлүүрээр үрийг бордооны хамт тарьж булдах ажлыг хослон хийж өдөр бүрийнхээ нормоо 120-130 хувь биелүүлж байна.

Тэнд хөдөлмөрийн баатар М. Чойжамц, улсын 4 удаагийн аварга комбайнч тракторчин Г. Баасан, М. Баасанхүү, Л. Ишгомбо, Жанцансэнгэ нар 4 өдөрт 6-8 өдрийн ажил хийж уралдааны манлайд явна. Тус САА-нхан энэ жил 31325 га газар үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал тарихаар өдөрт 125 аргатгай 1200 гаруй га хагалж, 68 аргатгай 3000 гаруй га газар үр суулгаж байна.

Ш. ЦЭРЭНДОО

АЙМГИЙН ҮЭ-ИЙН БАГА ХУРЛЫГ ИХ АМЖИЛТААР УГТЯА

Энэ оны 6 дугаар сарын 6-нд болох бага хурлыг угтсан хөдөлмөрийн өдрүүдэд манай аймгийн бүтээлч хөдөлмөрчид багдам сайхан амжилт гаргаж байна.

Одоогийн байдлаар таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд 5-аас дээш жилийн ажил гүйцэтгэсэн ажилчид 100 гаруй, 1973 оны төлөвлөгөөг биелүүлэгчид 3000 гаруй, албан үйлдвэрийн газар 23 байгаагийн дотор Угтаалын САА малаа таван төрөл дээр нь 5 жилийн эцэст байх хэмжээнд хүргэж, Батсүмбэрийн САА-н саалийн II, ногооны I, II бригадын хамт олон 3 жилд 4,1-5 жилийн ажил хийжээ.

СХ-ийн хөдөлгөөн эрчимтэй өрнөж 1971-1973 онд СХ-ийн төлөө, жинхэнэ бригад 23,3 хувь, гавшгайгай 21,4 хувиар өсч, одоо СХБ 316, СХТБ 129, ССН 35-тай болон.

V таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд 143 оногчтой санал, тэргүүн туршлага гарч 109 нь үйлдвэрлэлд нэвтрэн 106,8 мянган төгрөгийн хуримтлал бий болгов.

СХ-ийн сургуульд, орой, улирал, түр сургууль, эцнээгээр 1754 хүн суралцан төгсөж ерөнхий боловсролоор шат ахилаа.

Сүүлийн жилүүдэд хөдөлмөр хамгаалалын төсөв 200 гаруй мянган төгрөгөөр нэмэгдэж түр хуучээ алдагсадны тоо буурч үйлдвэрлэлтэй холбогдсон ослын тоо 30,3 хувиар багасав.

Улсын амралт сувилалд 7000-аад хүн амарсны дээр жирэмсэн эхэд олгох тэтгэмж 34,3, хүүхдийн арчилгаа тэжээлийн тэтгэмж 18,7, нийт олгосон тэтгэмж 40,5 хувиар өсчээ.

Уралдаант жилийн энэхүү амжилтаа улам ба-

татгаж бүх ард түмний социалист уралдаанд түрүүлэгчдийн чуулга уулзалтад оролцогчдоос гаргасан уриалгыг хэрэгжүүлж малын зүй бусын хоргодлыг багасгаж, мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, хамгийн бага зардлаар арвин их бүтээгдэхүүн үйлдвэрлэх, аж ахуй, соёлын жилийн төлөвлөгөөг тоо чанарын өндөр үзүүлэлтээр биелүүлэхийн тулд 6 өдрийн ажлыг 5 өдөрт хийх хөдөлгөөнийг бага хурлаа угтаж улам эрчимтэй өрнүүлэх зорилт тавигдаж байна.

Үүний тулд албан ба үйлдвэр, аж ахуйн газруудаас социалист уралдааныг улам үр нөлөөтэй болгож ажилчдаар нэмэлт хувийн тооцоотой үүрэг тодорхой авахуулж уралдааныг дүгнэх ажлын чанарыг дээшлүүлэх, доголдож байгаа ажлыг сайж-

руулах зорилгоор мэргэжилтнүүд бүтээлч ажлын төлөвлөгөөтэй ажиллах хөдөлгөөнийг өрнүүлэх ажлыг ҮЭ-ийн байгууллага зохион байгуулах хэрэгтэй.

МУЭ-ийн Төв Зөвлөлийн 1973 оны IV бүгд хурлаас ҮЭ-ийн ажлын үр нөлөөг улам дээшлүүлж, 1974 онд ҮЭ-ийн нийт ажлыг жигд сайжруулахаар гаргасан шийдвэрийг ҮЭ-ийн зөвлөл, хороо, комисс бүр хэрэгжүүлэх, мөн энэ онд ҮЭ-ийн бүлгийн ажиллагаанд хийх үзлэгт сайн бэлтгэж амжилттай дүн үзүүлэх нь аймгийн ҮЭ-ийн бага хурал угтсан ажлын чухал хэсэг байх ёстой.

Хөдөлмөрчдийн өсөн нэмэгдэж байгаа аж байдал, соёлын хэмжээг улам сайжруулах, ахуйн соёлын үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, хөдөлмөрчдийн өрүүл мэнд, урт удаан хугацаагаар хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэхэд ҮЭ-ийн байгууллагаас та-

вих хяналтыг эрс сайжруулж, БНМАУ-ын хөдөлмөрийн хуулийг хэлбэрлэлтгүй биелүүлдэг болгож, түүний биелэлтэд байнга судалгаа дүгнэлт хийж байвал зохино.

Аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн сүүлийн 2 жилийн ажлын тайланг хэлэлцэхэд анхан шатны хороо, зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар ҮЭ-ийн гишүүдийн 90-ээс доошгүй хувийг оролцуулж гишүүдийг хуралд идэвхтэй оролцуулан зарчимч шүүмжлэлийг өрнүүлэн цаашид ҮЭ-ийн байгууллагуудын ажлыг боловсронгуй болгон сайжруулах асуудлыг боловсруулах нь чухал байна.

Аймгийн ҮЭ-ийн бага хурлыг угтаж эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг байгууллага, тасаг, цех, ажилчин, тариачин, малчин бүр дээр урьдчилан гаргаж дүгнэлт хийж эхний хагас жилийн төлөвлөгөөг биелүүлдэг гэв.

Б. БАДАРЧ

СУРВАЛЖЛАХ ИДЭВХТЭН — СОНИНЫ ТҮШИГ Тулгуур

Саяхан манай сонины зөвлөдөөс 1974-онд аймгийн сонинд чухам юуг нийтлэвэл улам үр нөлөөтэй болох, сонины агуулга, үзэл суртал, хэл найрлага үзэмжийн талаар янз бүрийн ажил мэргэжлийн 326 хүнд саналаа нэмэрлэн үү? гэсэн хуудас тарааж саналыг авав. Мөн сонин уншигчдын бага хурлыг 16 суманд хийв.

Уншигчдын бага хуралд давхардсан тоогоор 500 шахам уншигчид оролцож 50 гаруй уншигч, сурвалжлах идэвхтэн үг хэлж санал шүүмжлэл гаргалаа.

Эдгээр хүмүүс «Анхдугаар таван жил» сонины үр нөлөө дээшлэж аймгийн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, социалист уралдааныг өрнүүлэх, хөдөлмөрчдийг хүмүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаад талархал илэрхийлжээ.

Ялангуяа «Анхдугаар

таван жил» сонины «Мал өсгөх нөөц бололцоо» гэсэн бага хурал нь аймгийн хэмжээгээр мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлэхэд ач холбогдол бүхий санал дүгнэлт олныг гаргав. Мөн бүх ард түмний социалист уралдааны талаар тогтмол гардаг нүүр, булан хамтын үзэлг сурвалжла-

10 гаруйг нь ажилдаа нэвтрүүлжээ.

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Б. Ажваа, Г. Алтанхүү, алдарт хоньчин Т. Ширчин, саальчин Ц. Хорлоо, багш Д. Цэвэгдорж, тракторчин Н. Болд нарын туршлагаар 40 шахам хүн ажиллаж байна гэжээ. Сонин хэвлэлээ хэдий үед уншдаг тухай

гууллагын тухай бичигдсэн зүйлийг онцлон уншиж, товч тэмдэглэл хөтөлж, заримыг ажилдаа нэвтрүүлж, орос хэлний эхнээ хичээлийг биеэ даан сурсан тухайгаа бичээд хойшид уг хичээлийг үргэлжлүүлэн гаргаж, олон улсын тойм, улс төр, эдийн засгийн өгүүллийг тогтмол бичиж найруулал, шог

Бас ахмад малчид дайчдын дурдатгал түүх, илгээлтийн эздийн ажил амьдрал, ЗСБНХОУ-ын Курган мужийн нам, захиргаа, олон нийтийн байгууллага, тэргүүний сайчуудын ажлын туршлага, сүүлийн үед ирсэн авто ба ХАА-н машин техник, хүлээн авагч, зурагт радиог эзэмших арга, марксизм-ленинизмын онолын эх зохиодын тухай тайлбар өгүүлэл зэргийг өргөн нийтэлж байхыг хүссэн байна.

Бас уншигчид маань сонины хэл найрлага үзэмж чанартай холбогдсон олон чухал-санал зөвлөгөө өгчээ. Иймээс манай сонины зөвлөл, редакцийн хамт олон уншигч олноо эдгээр саналаас ажилдаа дүгнэлт хийж сониныхоо агуулга, үзэл суртал үр нөлөөг улам сайжруулахын тулд тодорхой төлөвлөгөөтэй ажиллаж байна.

«АНХДУГААР ТАВАН ЖИЛ»
СОНИНЫ РЕДАКЦИ

УНШИГЧДЫН САНАЛ БОДОЛ

га, тэргүүн туршлага, уран зохиол, түмний хурц хараа, социалист уралдаан зэрэг нүүр, сонор чих хурц хараа, таны сонирхолд, орос хэлний эхнээ хичээл зэрэг булангууд нь бидний өдөр тутмын ажилд гүн тусалцаа үзүүлж, удирдлага зохион байгуулалт, үзэл суртал хүмүүжлийн үр нөлөөгөө өгч байна гэж дүгнэсэн байна. Өнгөрсөн онд сонинд нийтлэгдсэн туршлагауудаас

асуултанд хариулахдаа; олонхи уншигчид захиалсан хэвлэлээ хамгийн чухал удирдамж болох зүйлийг ажил дээрээ бусад туслах зүйлийг аль чөлөөтэй цагаараа уншдаг гэсэн байхад зарим хүмүүс ажил тасны дараа заавал 30 минутыг хэвлэл уншихад зориулж заншсан гэсэн байна. Тэгэхдээ тэргүүн туршлага, ШБОС, орос хэлний эхнээ хичээл, өөрийн сум бай-

найруулал, сурвалжлага, тэмдэглэл зэрэг сонин бичлэгийн гол гол төрөл зүйлийн бичлэгийг олшруулж аргачлан бичсэн тэргүүн туршлага, ШБОС, уран зохиол, социалист уралдаан, шинжлэх ухаан техникийн ололт, биеийн тамир спорт хийгээд эмч, багш нар хуулийн болон хүүхэд багачууд сурвалжлах идэвхтнүүдэд зориулсан нүүр буланг тогтмол гаргаж байхыг хүсчээ.

СУРВАЛЖЛАХ ИДЭВХТНҮҮДИЙН ЭРМЭЛЗЭХ БА ЦЭЭРЛЭХ ЗҮЙЛС

Сонин бичлэгийн төрөл зүйлийг бүрэн эзэмшиж давтагдашгүй, өвөрмөц бариллаар энгийн сайхан бичиж сурахад зориулж сурвалжлах идэвхтнүүдийн эрмэлзэх ба цээрлэх зүйлийн талаар товчхон өгүүлье.

Эрмэлзэх зүйлс
Сурвалжлах идэвхтэн хүнд жирийн амьдралын олон үзэгдлүүдээс хамгийн чухал зүйлийг сонгон олж хараад түүнээсээ нийгмийн ач холбогдолтой зүйлийг нээж гаргах, чадвар авхаалж самбаа чухал. Эс тэгвэл «Бичих сэдэв даанч олдохгүй байна л даа. Тэрнээс биш бичээд л баймаар байна» гэж явахад хүрнэ.

Сурвалжлах идэвхтэн бүр зохих хэмжээгээр ургуулан бодож чаддаг авъяас билэгтэй байх учиртай.

Ургуулан бодох авъяас билэг гэдэг нь нүдэнд үзэгдэмгүй мөртөө, уг зүйлийн гол шинж нь бодж буй өчүүхэн зүйлийг олж хараад, түүний мөн чана-

рыг нээж, жирийн хүмүүсийн нүдэнд харагдахуйц тод томруун болгож, уран сайхан дүрслэн бичих уран сэтгэлийн нэн их чадварыг хэлнэ. Үүний тулд юунаас нь эхлэх вэ? юугийг нь товчлох вэ? гэдгийг олон дахин бодож, боловсруулж сурах ёстой. Тэгж сурахын тулд хэлбэр агуулгын их эрэлд мордохын дээр онож хэлж, сонгож авч сурах нь чухал байдаг.

Ер нь сайн сэтгүүлчдийн бичсэн зүйлээс нэг л үг авчихвал үүдэн шүд нь уначихсан юм шиг харагдахаар тийм нарийн дэс дараалалтай бичигдсэн байдаг. Ингэж бичиж сурахад үгийн сангийн баялаг мэдлэг, шаргуу оролдлогоо хэрэгтэй.

Мөн ойр дотно харилцаж сониныхоо өвөрмөц арга барил, хэл найрлага, зохиомжинд суралцаж, сонин бичлэгийн төрөл зүйлийг нэг бүрчилэн ангилан үзэж, бүтээлчээр хэрэглэж чаддаг болох яв-

дал чухал юм. Ялангуяа мэдээ материалд чинь орсон хүн, байгууллагын нэр, тоо баримт хөдөлгөөнгүй үнэн байх, шүүмжлэлтэй зүйлийг тодорхой баримтаар ягштал нотолж бичих, гэхдээ зөвхөн шүүмжлэлд орхичих бус, түүнийхээ мөрөөр өөрсдөө хяналт шалгалт хийж, дутагдлыг заавал засуулж үр дүнгийн нь үзэх нь нэн чухал.

Цээрлэх зүйлс
Албан байгууллага, сум, бригадынхаа нэр, өөрийнхөө овог нэрийг дутуу бичих, товчлох, татлах, машиндсан мэдээнийхээ хорон хувийг өгч явуулахыг, бусад сонин хэвлэл радионд давхар өгөхийг, гараар бичвэл хэт шигүү бичих юм уу, дарж баллахыг цээрлэх хэрэгтэй. Мөн усын нэр томъёоны комиссоор батлагддаггүй нэр томъёо хэрэглэх, үг, үсгийн товчлол хийх, гадаад үг оруулах, эх материалгүй орчуулга ирүүлэх зэрэг нь шаардлагад нийцэхгүй.

Сэтгүүлч Б. ТОГООХҮУ

Үг бүрийг нягталмаар санагддаг

«Үг үсгээр хөөцөлддөг хүн» гэж зэмлэнгүйхэн шиг өгүүлж байгаа яриа сонсогдож л байдаг шүү дээ!

Тийм ч байж болох л биздээ. Харин аливаа бичиг баримт, түүний дотор сонин хэвлэлд материал бэлтгэж байгаа хүн, үг бүрээ нягтлах нь нэн чухал билээ.

Сонин хэвлэлд мэдээ материал бичнэ гэдэг бол зөвхөн өөрийнхөө бодол санааг төдийгүй, олон түмний хүсэл эрмэлзлэл, намын улс төр, эдийн засгийн бодлогыг илэрхийлж байгаа юм.

Ингэхлээр бичиж байгаа материал бүхнээ аль болох оновчтой үгээр, хүний ой ухаанд үлдэхүйц товч тодорхой илэрхийлэх явдал хичнээн чухал болох нь аяндаа ойлгомжтой.

Идэвхтэн бичигч, өөртөө тавих энэ шаардлагыг сулруулж, редакцийн ажилтны боловсруулалтад найдах нь нэг талаар бичлэгийнхээ чадварыг буу-

руулж, нөгөө талаар редакцийнхны «Үгийг барах» бас ч сониных цөөн хүний хэвшмэл маягийн хэллэгээр гаргахад хүргэж болдог.

Ийм учраас бичсэн зүйлээ ахин дахин уншиж, ёстой л «усы нь шахах»-ад хүццэг үлэмж зарцуулах нь зүйтэй юм шиг санагддаг. Бичсэн зүйлээ нягтлан уншихад хэд хэдэн үг буюу бүтэн өгүүлбэр биш ч гэсэн үг хасах боломж бишгүй гардаг.

Тухайлбал: «Эдгээр арга хэмжээнүүдийг авч ажилласны үр дүнд» гэсэн долоон үгийг «Үүний үрээр» гэж солиход хэвлэл найрлага утгын хувьд онцны ялгаа байхгүй.

Бичсэн зүйлээ нийтлэгдсэний дараа уншихад өдий төдий зүйлийг товчилж, цэгцлэхэд болохуйц зүйл тохиолдож байдаг. Ийм учраас бэлтгэсэн материалаа редакцид илгээхийн өмнө үг бүрээ нягтлан үзэх нь идэвхтэн бичигчдийн нэн чухал үүрэг байх билээ.

Сэтгүүлч А. ДАВААНЯМ

ЭЭЛЖИТ ШАГНАЛ, ОЛГОВ

«Анхдугаар таван жил» сонины зөвлөл 1973 онд цаг үеэ олсон, агуулга, хэл найрлага сайтай олон арван мэдээ сурвалжлага тэмдэглэл бичсэн Эрдэнэ сумын аптекийн эрхлэгч Д. Отгон, Намын хорооны ажилтан Р. Баярсайхан нарт «Анхдугаар таван жил» сонины ээлжит шагнал олгохоор тогтов.

Мөн бүх ард түмний социалист уралдааны жил 1973 онд уралдааныг сурталчлах талаар чухал түлхэц болохуйц мэдээ материал ирүүлсэн сурвалжлагч идэвхтэн НААҮГ-ын ажилтан Д. Хишигчулуун, гэрэл зурагчин А. Хэнмэдэх, ҮЭ-ийн зөвлөлийн ажилтан Д. Дуламжав, Баян сумын багш С. Чанцал, Жарганд, Дуламжав, Баян сумын багш С. Чанцал, Жаргандын САА-н намын хорооны зааварлагч Ш. Ядамсүрэн нарт тусгай шагнал олгов.

Манай сурвалжлагч

ГЭРЭЛ ЗУРАГ СОНИРХОГЧ ИДЭВХТЭНД САНАМЖ

Сонины зургийг авахдаа урьдаас төлөвлөгөө чиглэлтэй ямар үйл амьдрал хөдөлгөөнийг хэрхэн тусгахдаа нарийн боловсруулж цаг үеийн ээлжит зорилттой холбож үйл амьдралыг уран нарийн тусгах хэрэгтэй.

Нэг үйл амьдрал хөдөлгөөн дээр зураг авахдаа урьд өмнө нь хэвлэл дээр гарч байгаагүй тийм дүр, үйл хөдөлгөөнийг сонгон харуулахыг чармайх нь

чухал. Жишээ нь хургачин гэсэн сэдвээр зураг авахдаа хурга тэврэсэн эсхүл хариулж яваагаас өөр олон төрлийн өвөрмөц сонирхолтой хөдөлгөөнийг уран харуулахыг хичээвэл зохино.

Гэрэл зураг сонирхогчдоос сонин хэвлэлийн газар ирж байгаа зургийн ихэнх нь урьд өмнө хэвлэлд гарч байсан үйл амьдрал хөдөлгөөнийг дүр байдлыг давтсан шинж-

тэй байна. Тракторчны уринш хагалж яваа зургийг авахдаа талбайн соёлжилт уул, үүлийг нар гэрлийн байдлад зөв зохицуулах нь зүйтэй.

Цагаан цайвар өнгөтэй зүйлийн зургийг нарны эсрэг талаас авахад тод томруун гардаг. Бэлчээрт яваа хонины зургийг нарны эсрэг талаас авахад хар цагааны ялгарал сайн байдаг.

О. СУМБЯА



●Сайгоны засаг захиргаа Парисын хэлэлцээрийн заалтыг байнга зөрчиж Өмнөд Вьетнамын байдлыг санаатайгаар хүндрүүлэхийг оролдож байна. Сайгоныхан энэ 5 дугаар сарын 3-ны өдөр, Вьетнамд дайныг зогсоох тухай хоёр талын цэргийн комиссын ажиллагааг бүрэн тасалдуулж БНӨВУ-ын цэргийн комиссыг гадаад ертөнцөөс зааглан утас телефоныг хүртэл тасалжээ.

Одоо Өмнөд Вьетнамд дайны гал дахин дүрэлзэж, Вьетнамын байдал хурцадлаа.

Сайгоны харгис дэглэмийнхэн энэ он гараад БНӨВУ-ын түр засгийн газрын харьяаны газар нутагт 5,2 мянга газар удаа зөрчил үйлдсэний гадна сүүлийн үед булаан эзлэх дайн хийж байна.

АНУ, сайгоныханд 700 мянган тонн бөмбөг, тэр э х зэвсэг 900 танк, хуягт машин, 600 гаруй төрөл бүрийн их буу бусад олон мянган зэр зэвсэг нийлүүлжээ.

Мөн энэ онд АНУ 1,45 миллиард долларыг сайгоны засаг захиргаанд тусламж болгохоор төлөвлөжээ. АНУ-ын энгийн хувцас өмсөн цэргийн албан

АШИГТАЙ АЛХАМУУД

Сүүлийн хэдэн 7 хоногт манай гаригийн хүн төрөлхтний түүхэнд шинэ шинэ үйл явдлаар дүүрэн болж өнгөрдөө.

Олон улсын түгшүүртэй байдал намжиж байгаагийн бас нэг тод жишээ нь Лаос, Өмнөд Азийн салбар тив, Ойрхи Дорнодын мөргөлдөөнийг улс төрийн аргаар зохицуулахад ашигтай алхам хийсэн явдалд оршино.

хаагчид өмнөд Вьетнамд 25 мянгад хүрээд байгаа ба цаашид нэмэгдэх төлөвтэй байна.

●Лаосын засгийн эрх барих эвслийн шинэ байгууллагууд хэвийн ажиллагаа явуулж эхлэж байна. Эх оронч хүчний төлөөлөгчдийн гаргасан санаачлагын үр дүнд өнгөрсөн сард зохион байгуулалтын хэд хэдэн асуудлыг шийдвэрлэжээ. Улс төрийн үндэсний эвслийн зөвлөлийн анхдугаар чуулган 4 дүгээр сарын 25-нд нээгдэж хэд хэдэн комисс байгуулагдан, хоёр этгээдийн (засгийн газар) төлөөлөгчид эдгээр комисст эвслийн зөвлөлийн үйл ажиллагааны янз бүрийн асуудлыг хэлэлцүүлж байна.

Сүүлийн өдрүүдэд Израилийн дайчид Ливан, Сирийн нутаг дэвсгэрийг дайран довтлох явдлаа хүчтэй болгов.

Тухайлвал 4 дүгээр сарын 27, 28, 30, 5 дугаар сарын 2, 3-ны өдрүүд Ливаны нутгийн гүнзүү нэвтрэн оржээ.

Үүний зэрэгцээгээр Си-

ри, Израилийн секторт ширүүн тулалдаан явагдаж, гал зогсоосон шугамын янз бүрийн хэсэгт Израилийн түрэмгийлэгчид их буугаар буудаж байна.

●НУБ-ын ерөнхий Ассамблейн VI тусгай чуулган 4 дүгээр сарын 9-нээс 5 дугаар сарын 8-ны өдрийг хүртэл хуралдаж, «Байгалийн нөөц, эдийн засгийн хөгжлийн асуудал» хэлэлцэв.

Тус чуулганаас үндсэн баримт бичиг болох олон улсын эдийн засгийн харилцааны шинэ журам тогтоох тухай тунхаглал, үйл ажиллагааны программ батлав.

Энх тайвнаар зэрэгцэн оршиж, бүх улс орон эрх тэгш хамтран ажиллах зарчмын дагуу шинэ тулгуур орнууд болон хөгжингүй орнуудын харилцааг эрс өөрчлөх замаар л энэ асуудлыг шийдвэрлэж болох талаар, мөн империалист монопол болон колоничлолын дэглэмийг устгахыг тодорхойлсон юм.

(Үргэлжлэл бий)

Баасан сайн сувилагч


Аймгийн артельд таван жил оёдолчин хийсэн Б. Баасан хүн эмнэлгийн газар ажиллах чин хүсэлдээ хөтлөгдөн 1952 онд асрагчаар оржээ.

Түүнээс хойш асрагчийн ажилдаа дадлагажин улмаар аймгийн төвд хичээллэж байсан сувилагчийн 3 сарын курст суралцан амжилттай төгсч хүсэлдээ хүрчээ.

Шинэ сувилагчид, ажил их, мэдэхгүй зүйл мандахгүй байвч эмч, сувилагч нарын заасныг дор нь сурч сайн сувилагч болохоо харууллаа.

Би өвчтөнтэй эелдэг харьцаж шаардлагатай тариаг цаг тухайд нь хийхийг хичээдэг гэж тэр яриу.

С.ОТГОН



Саяхан Зуунмод хотод явдагдсан өсвөрийн дугуйчдын тэжээний цом авсан Батсүмбэрийн САА-н 8 жилийн дунд сургуулийн сурагч (зүүн - гараас) А. Батсайхан, Н. Оюунцэцэг, багш Аюушрагчаа, сурагч Б. Баирхүү, Д. Оюундэлгэр.

Л. ДАМДИНДОРЖ-ийн авсан гэрэл зураг

ЗУРАГ ДЭЭР: (баруун гараас) 10 км-ийн зайн уралдаанд II, III байр эзэлсэн аймгийн төвийн 10 жилийн дунд сургуулийн сурагч Ж. Дашдаваа, С. Түмэндэлбэрэл.



Хөдөлмөрчдийн хууль ЗҮЙН МЭДЛЭГТ

Эрүүгийн ял шийтгэлийн тухай

БНМАУ-ын эрүүгийн хуульд ял шийтгэлийн зорилгыг тодорхойлохдоо; шийтгүүлэгчдийг үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд сахидаг хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэн үздэг болгон засч хүмүүжүүлэх, шийтгүүлэгчдийг дахин гэмт хэрэг үйлдэх, бусад хүмүүсийг гэмт хэргээр үйлдэхээс урьдчилан сэргийлэх ба хүний бие махбодыг зовоох, хүн гэсэн нэрийг гутаах зорилготой гэж заасан билээ. Энэ заалт бол манай эрүүгийн эрхээр хүмүүжүүлэх явдал ял шийтгэлийн гол зорилго мөнхийг тодорхойлж байна.

Эрүүгийн хууль зөрчиж гэмт хэрэг нэгэнт хийсэн хүнийг гэм буруутайг нь тогтоосны дараа ял шийтгэл оногдуулдаг.

БНМАУ-ын эрүүгийн хуульд заасан ял шийтгэлийг үндсэн ба нэмэгдэл ял гэж хоёр хуваана.

Гэмт хэрэг үйлдэгсдэд хорих, нутаг зааж суулгах, уг нутгаас зайлуулах, засан хүмүүжүүлэх

ажил хийлгэх, ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох, торгох, олон нийтийн өмнө буруушаах үндсэн ял оногдуулан ял шийтгэгдсэн этгээдэд эдгээр үндсэн ялаас гадна хөрөнгийг хураах, цэргийн ба тусгай алдар цолыг хасгах, мөн дээр дурьдсан үндсэн ял болох нутаг зааж суулгах, уг нутгаас зайлуулах, ямар нэгэн тодорхой албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох, торгох ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэж болохыг эрүүгийн хуулинд заажээ.

Хорих ял бол эрүүгийн үндсэн ялын хамгийн хүнд ял юм.

Хорих ялын дээд хэмжээг 10 жил, доод хэмжээг 6 сар байхаар тогтоосон байна.

Үргэлжлэл бий

ТАРИАЛАНЧДЫН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛД АНХААРЬЯ

Тус аймгийн нийт САА, ХАА-н нэгдлүүдийн тариалантын бэлтгэлийг хангасны дотор Угтаал, Жаргалантын САА бусдаасаа илүү байна.

Угтаалын САА тариаланчдын хөдөлмөр хамгаалалыг сайн анхаарч бригадынхаа тракторчдын байргыг чанартай засварлаж бүрэн хэрэглэртэй цагаан ортой болгоосон ба Угтаал, Баянцогт, Жаргалантын САА-нууд үрэлгээний бүх агрегатыг дуут дохиотой, бүх тракторчдыг кабины эмийн сантай, Баянцогтын САА, техник механизмын хаалт хамгаалалтыг бүрдүүлэн, анхааруулга санамж дохиотой болгожээ.

Мөн зарим САА-нуудад жолооч техникчдэд мэргэжил дээшлүүлэх, аюулгүй ажиллагааны арга барил, хөдөлмөрийн хууль тогтоомжуудаар хичээл зааж шалгалт авч, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлийн жагсаалт гарган хувцас хэрэгсэлийг олгож өгчээ.

Гэвч хувцас хэрэгсэлийг бүрэн олгох аюулгүй ажиллагааны арга барилын зааварчлагыг тогтмол чанартай өгөх, ажлын

тусгай хувцас хамгаалах хэрэгсэлийг цэвэрлэх, засварлах техникчдыг халуун усаар үйлчлэхгүй байгаа дутагдал нилээд газар үзэгдэж байна.

Инженер техникчийн ажилтнуудын хөдөлмөр хамгаалалын мэдлэгийг дээшлүүлэх, шалгалт авч байх, ажлын явцад ажлын тусгай хувцас хэрэгсэлээ өмсөж хэрэглэж хэвшүүлэх, ажил хангалтгүй байна. Бригадуудад байвал зохих аж ахуйн зүйлүүд нүүр гарын угаагуур, радио байхгүй, талх махыг шуудайгаар зөөж байгаа болон жолооч техникчдын хоолонд ногоо хэрэглэхгүй, сүү цагаан идээгээр хангах, хоолны амт чанарыг сайжруулан нэр төрлийг олшруулах, үүнийг хямдруулах талаар муу анхаарч байна.

Тракторын чиргүүл дээр хүн суулгахыг зогсоож жолооч техникчид, туслах ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт оруулж, хамтын гэрээ Социалист уралдааны үүрэг амлалтанд хөдөлмөр хамгаалалын асуудлыг тусгаагүй байна. Хөдөлмөр хамгаалалын ажлыг сурталчлах төв болох хөдөлмөр хамгааллын булан кабинет байгуулан, тохижуулах, түүнийг нүүдлийн хэлбэрээр зохион байгуулж ашиглах, талбайд хөдөлмөр хамгааллын эргүүл пост, бригадуудад ҮЭ-ийн түр бүлэг ажиллуулах, осол зөрчилгүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэх нь чухал.

Хөдөлмөр хамгааллын
улсын байцаагч
Ш. БАТТУЛАГА

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

ЗАРЛАЛ

Зуунмод хотын 4 дүгээр хорооны харьяат Цэрэндүлам овогтой Даваасүрэн, мөн хорооны харьяат Мэнд овогтой Пүрэвээс гэрэлтээ цуцлуулахаар сэдсэн өргөдлийг аймгийн нүүдлийн 1 дүгээр шүүх хянаж байна.